

НИЙСЛЭЛИЙН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРШИЛТАЙ УЛСЫН ОНЦ ЧУХАЛ ОБЪЕКТ,
ГАЛ ТҮЙМРИЙН ОНЦ АЮУЛТАЙ БОЛОН ГАЛ ТҮЙМРИЙН АЮУЛТАЙ
I, II ЗЭРГИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИД ХЯНАЛТ
ШАЛГАЛТ ЯВУУЛСАН ТУХАЙ

2018.04.16.

Улаанбаатар хот

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2017 оны 04 дүгээр сард өгсөн үүрэг даалгаврын дагуу нийслэлийн нутаг дэвсгэрт байршилтай улсын онц чухал объект, гал түймрийн онц аюултай болон гал түймрийн аюултай I, II зэргийн барилга байгууламжийн галын аюулгүй байдал болон объектын галын дохиоллын системийн угсралт, ашиглалт, хэвийн ажиллагаанд тавих хяналт шалгалтыг 2017 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 2018 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн хооронд Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай, Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, түүнтэй нийцүүлэн гаргасан галын аюулгүйн норм нормативын баримт бичгийн хүрээнд зохион байгуулж ажилласан.

**Нэг. Гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтыг
хэрэгжүүлэх чиглэлээр 2017 онд хийсэн ажлын талаар**

Онцгой байдлын ерөнхий газраас 2017 онд Монгол Улсын Шадар сайдын баталсан 4 удаагийн удирдамж, Онцгой байдлын газрын ерөнхий газрын даргын баталсан 4 удаагийн удирдамж, нийслэлийн Засаг даргын баталсан захирамжаар 1 удаагийн, нийслэлийн Онцгой байдлын газрын даргын баталсан 7 удаагийн удирдамжаар төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн шалгалтуудыг нийслэлийн нутаг дэвсгэрт байршилтай Улсын онц чухал объект, галын аюултай объект, Засгийн газрын байрууд, төрийн захиргааны байгууллага, үзвэр үйлчилгээ, соёл урлагийн байгууллага, эрүүл мэнд, боловсрол, сүм хийд, шашны байгууллага, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн санал авах байрууд, баяр наадмын үйл ажиллагаа явуулж буй газрууд, газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, борлуулдаг аж ахуйн нэгж байгууллагууд, Эрчим хүч үйлдвэрлэдэг, түгээгч байгууллагууд, зочид буудал, аялал жуулчлалын газар, олон хүн төвлөрсөн худалдааны төв, зах, авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагуудад гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналт шалгалтыг зохион байгуулж, шалгалтын дүнг нэгтгэн, нийслэлийн Онцгой байдлын газрын даргын 2017 оны 10/184, 10/208, 10/226, 10/288, 10/371, 10/484, 10/487, 10/494, 10/546, 10/557, 10/558, 10/581, 10/714, 10/829, 0/988, 10/1089 дугаартай албан бичгүүдээр Онцгой байдлын ерөнхий газар, нийслэлийн Засаг дарга, бусад холбогдох байгууллагуудад цаг тухайд нь тус тус хүргүүлэн танилцуулж ажилласан.

Батлагдсан удирдамжийн хүрээнд гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналт шалгалтаар нийт **10312** объект хамрагдсанаас нийслэлийн Онцгой байдлын газар **167**, Баянгол дүүргийн Онцгой байдлын хэлтэс **1432**, Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтэс **1274**, Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтэс **1566**, Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтэс **1547**, Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтэс **1477**, Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтэс **1298**,


Багануур дүүргийн Онцгой байдлын хэлтэс **595**, Багахангай дүүргийн Онцгой байдлын хэлтэс **322**, Налайх дүүргийн Онцгой байдлын хэлтэс **634** объектыг тус тус шалгаж, галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, стандарт, норм, нормативын холбогдох заалтыг зөрчсөн **53351** зөрчил илрүүлж, **12661** зөрчил буюу **23.7** хувийг газар дээр нь арилгуулан, бусад зөрчлүүдийг арилгуулахаар Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага **2811**, мэдэгдэл **3617**, ажиллагаа зогсоох тогтоол **74**, танилцуулга **168**, дүгнэлт **978**-ыг тус тус бичиж, эрх бүхий албан тушаалтнуудад хүргүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажилласан.

Шалгасан ААНБ-ын тоо (2017 он)




2017 онд нийт 10312 объект шалгалтанд хамрагдсан.

Илрүүлсэн, арилгуулсан зөрчил (2017 он)



Шалгалтаар нийт илрүүлсэн зөрчил 53351, арилгуулсан зөрчил 12661.

2017 онд бичсэн эрх зүйн баримт



Заавал биелүүлэх албан шаардлага-2811, мэдэгдэл-3617, ажиллагаа зогсоох тогтоол-74, дүгнэлт-978, танилцуулга-168.

Шалгалтаар Зөрчлийн тухай хуулийн 5.14 дүгээр заалтыг үндэслэн Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн, галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичгийн шаардлагыг биелүүлж ажиллаагүй 148 иргэнийг 30.430.000 төгрөгөөр, 28 албан тушаалтныг 1.950.000 төгрөгөөр, 135 хуулийн этгээдийг 66.245.000 төгрөгөөр, нийт 311 субъектыг 99.125.000 /ерэн есөн сая нэг зуун хорин таван мянган/ төгрөгөөр торгож захиргааны арга хэмжээ тооцож ажилласан.

Захиргааны арга хэмжээ тооцсон дүн (2017 он)



Нийт 311 субъектыг 99.125.000 төгрөгөөр торгож, захиргааны арга хэмжээ тооцсон.

Иргэн, аж ахуйн нэгж байгууллагад гамшиг болон галын аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтыг 684 удаа, дадлага сургуулийг 354 удаа тус тус зохион явуулж, нийт 725648 хүнийг хамруулан, Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, түүнтэй нийцүүлэн гаргасан норм дүрэм, стандартын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар байгууллагуудын удирдлага, албан тушаалтан, менежер, зохион байгуулагч нарт сурталчилж, хууль тогтоомжийг сахин биелүүлэх, галын аюулгүй байдлын норм, нормативын шаардлагыг дагаж мөрдөж ажиллах талаар анхааруулж, мэргэжлийн заавар зөвөлгөөг өгч ажилласан.

Шалгалтын явцын талаар болон гарсан гамшиг, гал түймрийн нөхцөл байдал, галын аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр Монголын үндэсний олон нийтийн радио телевиз, Монгол HD телевиз, С-1, UBS, TV-5, TV-8, TV-9, 25 дугаар суваг телевиз, нийслэлийн Онцгой байдлын газрын веб сайт, бусад веб сайт, сонин зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийт 347 удаа иргэд, олон нийтэд сурталчиллаа.

Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагаас 2017 онд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлж, улсын хяналт шалгалт явуулах эрх бүхий албан тушаалтан нарт мэргэжлийн заавар зөвөлгөөг давхардсан тоогоор 12 удаа өгч, шинээр батлагдсан хууль тогтоомж, норм дүрэм, стандартуудыг мэргэжлийн байгууллагуудаас авч, Гал түймрийн улсын хяналтын байцаагч нарт хүргүүлж, ажлын хэрэгцээнд ашиглуулсан бөгөөд хууль, эрх зүйн мэдлэг, ур чадварыг нь дээшлүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудас 2 удаагийн сургалтыг зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар ханган ажилласны үр дүнд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад шалгасан объектын тоо 1.59 хувиар, илрүүлсэн зөрчлийн тоо 7.76 хувиар, газар дээр нь арилгуулсан зөрчлийн тоо 22.07 хувиар, иргэн, хуулийн этгээдэд захиргааны арга хэмжээ тооцсон байдал 28.47 хувиар, зөрчил арилгуулахаар бичсэн эрх зүйн баримт бичиг тухайлбал заавал биелүүлэх албан шаардлага 23.86 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.


Хоёр. Гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналт шалгалтын чиглэлээр 2018 оны 1 дүгээр улиралд хийсэн ажлын талаар

Нийслэлийн Онцгой байдлын газраас 2018 оны 1 дүгээр улиралд Монгол Улсын Шадар сайдын баталсан 1 удаагийн удирдамж, Онцгой байдлын газрын ерөнхий газрын даргын баталсан 1 удаагийн удирдамж, нийслэлийн Онцгой байдлын газрын даргын баталсан 1 удаагийн удирдамжаар шалгалтуудыг Төрийн ордон, Засгийн газрын байрууд, төрийн захиргааны байгууллага, үзвэр үйлчилгээ, соёл урлагийн байгууллага, сүм хийд, шашны байгууллагын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагуудад гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналт шалгалтыг зохион байгуулж, шалгалтын дүнг нэгтгэн, нийслэлийн Онцгой байдлын газрын даргын 2018 оны 10/254, 10/306, 10/491 дугаартай албан бичгүүдээр Онцгой байдлын ерөнхий газарт цаг тухайд нь хүргүүлэн танилцуулж ажилласан.

Шалгалтаар нийт **2272** объект хамрагдсанаас нийслэлийн Онцгой байдлын газар **259**, Баянгол дүүргийн Онцгой байдлын хэлтэс **257**, Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтэс **249**, Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтэс **291**, Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтэс **266**, Хан-Уул дүүргийн Онцгой

байдлын хэлтэс **240**, Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтэс **274**, Багануур дүүргийн Онцгой байдлын хэлтэс **180**, Багахангай дүүргийн Онцгой байдлын хэлтэс **62**, Налайх дүүргийн Онцгой байдлын хэлтэс **194** объектыг тус тус шалгаж, галын аюулгүйн дүрэм, норм, стандартын холбогдох заалтыг зөрчсөн **16138** зөрчил илрүүлж, **6652** зөрчил буюу **41.2** хувийг газар дээр нь арилгуулан, бусад зөрчлүүдийг арилгуулахаар Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага **725**, мэдэгдэл **1414**, ажиллагаа зогсоох тогтоол **22**, танилцуулга **35**, дүгнэлт **231**-ийг тус тус бичиж, байгууллагуудын шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажилласан.

Шалгасан ААНБ-ын тоо 2018 оны 1 улирлын байдлаар




2018 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 2272 объект шалгалтанд хамрагдсан.

Илрүүлсэн, арилгуулсан зөрчил (2018 он)



Шалгалтаар нийт 16138 зөрчил илрүүлж, 6652 зөрчлийг арилгуулсан.

2018 оны 1 дүгээр улиралд бичсэн эрх зүйн баримт бичиг



Заавал биелүүлэх албан шаардлага-725, мэдэгдэл-1414, ажиллагаа зогсоох тогтоол-22, дүгнэлт-231, танилцуулга-35.

Шалгалтаар Зөрчлийн тухай хуулийн 5.14 дүгээр заалтыг үндэслэн Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн, галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичгийн шаардлагыг биелүүлж ажиллаагүй 77 иргэнийг 14.700.000 төгрөгөөр, 5 албан тушаалтныг 2.300.000 төгрөгөөр, 21 хуулийн этгээдийг 15.400.000 төгрөгөөр, нийт 103 субъектыг 32.400.000 /гучин хоёр сая дөрвөн зуун мянган/ төгрөгөөр торгож шийтгэлийн арга хэмжээ тооцож ажиллалаа.

2018 оны 1 дүгээр улирлын байдлаар захиргааны арга хэмжээ тооцсон дүн



Нийт 103 субъектыг 32.400.000 төгрөгөөр торгож захиргааны арга хэмжээ тооцож ажилласан.

Одоогийн байдлаар Монгол Улсын Шадар сайдын баталсан удирдамж, хуваарийн дагуу “Боловсролын байгууллага”-д гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөт хяналт шалгалтыг нийслэл, орон нутгийн хэмжээнд мөн Оросын Холбооны Улсын Кемерово хотын төвд байрлах “Өвлийн интоор” нэртэй худалдаа, үйлчилгээний барилга байгууламжид гал түймэр гарч, олон хүний амь нас үрэгдэж, их хэмжээний эд материалын хохирол учирсантай холбогдуулан нийслэлийн Засаг даргын захирамжаар холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтарсан ажлын хэсэг томилогдон нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа томоохон худалдаа, үйлчилгээний барилга байгууламжид төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг тус тус зохион байгуулан ажиллаж байна.

Гурав. Хүрсэн үр дүн

Шалгалтын явцад Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1 дэх заалтын дагуу 178 аж ахуйн нэгж байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг баталж, 225 төлөвлөгөөнд тодотгол хийж, гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулахад мэргэжлийн заавар зөвөлгөөг өгч аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажилласан.

Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.6 дахь заалт, Галын техник. Зөөврийн гал унтраагуур.Туршилтын аргачлал MNS 6413:2013 стандартын дагуу 1976 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын барилга байгууламжийн гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж, анхан шатны багаж хэрэгсэл зэрэгт техникийн үйлчилгээ, нөхөн хангалтыг хийлгүүлж, ашиглалтын бэлэн байдлыг хангуулсан.

Гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналт шалгалтаар 2017 онд нийт 10312 объект хамрагдсанаас Барилга байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл БНБД 21-04-05 норм дүрмийн 12 дахь заалтын дагуу галын дохиоллын систем сууриллуулаагүй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын барилга байгууламж Баянгол дүүрэгт 194, Баянзүрх дүүрэгт 211, Сонгинохайрхан дүүрэгт 81, Сүхбаатар дүүрэгт 252, Хан-Уул дүүрэгт 240, Чингэлтэй дүүрэгт 104, Багануур дүүрэгт 35, Багахангай дүүрэгт 8, Налайх дүүрэгт 32 объект, нийт 1157 объект галын дохиоллын систем сууриллуулаагүй байна.

Тухайлбал Улаанбаатар хотод 1950, 1960-аад онд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын тусламжаар баригдсан Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт байрлах 40, 50 мянгатын орон сууцны 3 давхар барилгууд, мөн Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт баригдсан Үйлдвэр компинат, Нисэх, Яармагийн орчмын орон сууцны 2, 3 давхар барилгууд, Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн Энхтайван, Хувьсгалчдын өргөө чөлөө зэрэг гудамж /хүнсний 1, хүнсний 4 дүгээр дэлгүүр/ орчимд байрлах 2, 3 давхар орон сууцны барилгууд, тухайн үеийн Зөвлөлт Холбоот Улсын тусламжтай 1970 аад оноос нийслэл, дүүргийн нутаг дэвсгэрт баригдсан тоосгон, угсармал орон сууцны 5, 9 давхар барилгуудад галын дохиоллын системийг суурилдаагүй бөгөөд нийт 1157 объектоос хуучны олон жилийн насжилттай орон сууцны барилгууд 550 буюу 47,5 хувийг, 1990 оноос өмнө баригдсан төрийн захиргааны байгууллага болох Шүүх, Цагдаа, Прокурор, Шүүхийн

шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харъяа хорих ангийн барилга, нийслэлийн, дүүргийн Засаг даргын Тамгын газрын барилга байгууламжууд 30 хувийг, үлдсэн 22.5 хувийг хуучны үйлдвэр, үйлчилгээний зориулалттай баригдсан барилга байгууламжууд эзэлж байна.

Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.3, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт, Барилга байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл БНБД 21-04-05 норм дүрмийн 4, 12 дахь заалтын дагуу 2017 онд шинээр баригдах иргэн, аж ахуйн нэгж байгууллагын 232 барилга, 2018 оны 1 улиралд 73 барилгын зураг төсөлд хяналт тавьж, объектод гал унтраах автомат төхөөрөмж болон галын дохиоллын систем сууриллуулах талаар мэргэжлийн заавар зөвөлгөөг өгч, 2017 онд 329 объект, 2018 оны 1 дүгээр улиралд 52 объектод улсын комиссын гишүүнээр ажиллаж, дээрх ашиглалтанд орсон барилга байгууламжуудад холбогдох хууль тогтоомж, норм дүрмийн дагуу галын дохиоллын системийг шинээр сууриллуулж, галын аюулгүй байдлыг хангуулсан бөгөөд 314 объектын галын дохиоллын системийн засвар үйлчилгээ хийлгүүлж, хэвийн ажиллагааг хангуулсан болно.

ГАЛ ТҮЙМЭРТЭЙ ТЭМЦЭХ ГАЗАР